Зөвшөөрөл олгох, сунгах үндэслэл журам: Зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйл. Зөвшөөрөл олгох, сунгах журам

Түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам: Зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар бүлэг. Зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох

Сэргээсэн, хүчингүй болгосон зөвшөөрлийн талаарх мэдээлэл: Зөвшөөрлийн тухай хуулийн 6.1, 6.2, 6.3, 6.4 дүгээр заалтуудыг үндэслэн

Хүчингүй болгосон зөвшөөрлийн талаарх мэдээлэл: Өнөөдрийн байдлаар хүчингүй болгосон тусгай зөвшөөрөл байхгүй.

Байгууллагын нэр: Цагдаагийн ерөнхий газрын Зөвшөөрөл, үйлчилгээний төв.

Байгууллагын хаяг, утасны дугаар: Баянгол дүүргийн 1 дүгээр хороо, Замчдын гудамж Премиум апартаментийн байр. Утас: 70191515

Хариуцсан албан тушаалтны нэр, утасны дугаар: Ахлах мэргэжилтэн, цагдаагийн дэд хурандаа Б.Баттулга 93081111

МОНГОЛ УЛСЫН ИРГЭН УЛСЫН ХИЛЭЭР ГАЛТ ЗЭВСЭГ, ГАЛТ ЗЭВСЭГТЭЙ АДИЛТГАХ ХЭРЭГСЭЛ НЭВТРҮҮЛЭХ


Үйлчилгээний төрөл: Монгол улсын иргэн улсын хилээр галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл нэвтрүүлэх.

Шийдвэрлэх хууль, журам: Галт зэвсгийн тухай хуулийн 19 дугаар зүйл. 19.2. Галт зэвсэг өмчлөх эрхтэй Монгол Улсын иргэн өөрөө өмчлөх зорилгоор энэ хуулиар хориглоогүй нэг галт зэвсгийг жилд нэг удаа улсын хилээр оруулах эрхтэй. Иргэн өөрөө өмчлөх зорилгоор оруулж ирсэн галт зэвсгийг оруулж ирснээс хойш гурван жилийн дотор бусдад худалдах, бэлэглэхийг хориглоно. 19.4. Энэ хуулийн 9.1-д заасан шаардлагыг хангасан Монгол Улсын иргэн галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг улсын хилээр оруулж болно. Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 10.8 дугаар заалт.

Шийдвэрлэх хугацаа: ажлын 5 хоног

Бүрдүүлэх бичиг баримт:

1. 21 насанд хүрсэн байх
2. Галт зэвсэг худалдан авах тухай хүсэлт
3. Оршин суугаа хаягийн тодорхойлолт /ТҮЦ машины лавлагаа/
4. Иргэний үнэмлэхний хуулбар /ТҮЦ машины лавлагаа/
5. Цээж зураг 2% /2*3 хэмжээтэй/
6. ЦЕГ-ын тодорхойлолтын мөнгөн шилжүүлгийн баримт /төрийн сан 100900012027 дансанд тодорхойлолтын үнэ 1000 төгрөг/
7. Галт зэвсгийн зураг, нэр, төрөл, үйлдвэрлэсэн он, сериал дугаарыг тодорхойлох баримт, бичиг /инвойс/
8. Худалдаж авсан галт зэвсгийн зураг, техникийн өгөгдөхүүн
9. Галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах аюулгүй ажиллагааны сургалтад хамрагдсан гэрчилгээний хуулбар /Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төв 70190092/
10. Галт зэвсэг ашиглахад харшлах өвчин, гэмтэл согоггүйг тодорхойлсон эрүүл мэндийн хуудас. /харьяа дүүргийн эрүүл мэндийн төвөөс А/33 маяг/



Төлбөр: Үгүй

Хураамж: Үгүй

Зөвшөөрөл олгох, сунгах үндэслэл журам: Зөвшөөрлийн тухай хуулийн 10.8 дугаар зүйл.

Түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам: Зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар бүлэг. Зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох

Сэргээсэн, хүчингүй болгосон зөвшөөрлийн талаарх мэдээлэл: Зөвшөөрлийн тухай хуулийн 6.1, 6.2, 6.3, 6.4 дүгээр заалтуудыг үндэслэн

Хүчингүй болгосон зөвшөөрлийн талаарх мэдээлэл: Өнөөдрийн байдлаар хүчингүй болгосон энгийн зөвшөөрөл байхгүй.

Байгууллагын нэр: Цагдаагийн ерөнхий газрын Зөвшөөрөл, үйлчилгээний төв.

Байгууллагын хаяг, утасны дугаар: Баянгол дүүргийн 1 дүгээр хороо, Замчдын гудамж Премиум апартаментийн байр. Утас: 70191515

Хариуцсан албан тушаалтны нэр, утасны дугаар: Ахлах мэргэжилтэн, цагдаагийн дэд хурандаа Б.Баттулга 93081111

ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЭЛ ТЭЭВЭРЛЭХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛД ОЛГОХ ЗӨВШӨӨРӨЛ

Үйлчилгээний төрөл: Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл тээвэрлэх тээврийн хэрэгсэлд олгох зөвшөөрөл.

Шийдвэрлэх журам: “Зөвшөөрлийн тухай хууль”-ын 8 дугаар зүйл 8.2.7.1, “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль”-ын 14 дүгээр зүйл 14.1, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн хамтарсан А/246, А/189 дүгээр тушаалаар баталсан “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн аюулгүй ажиллагааны журам”, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам код 605

Хугацаа: “Зөвшөөрлийн тухай хууль”-ын 5 дугаар зүйл 5.2 дахь хэсэг

Бүрдүүлэх баримт бичиг:

- 1.Зөвшөөрөл хүссэн аж ахуйн нэгжийн албан бичиг.
- 2.Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ. /хуулбараар/
- 3.Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрөл. Тэсэрч дэлбэрэх бодис тэсэлгээний хэрэгсэл импортлох, худалдах, үйлдвэрлэх, үйлдвэрлэлийн зориулалттай тэсэлгээний ажил үйлчилгээ эрхлэх, тээвэрлэх г.м / хуулбараар/
- 3.Тухайн ангилалд тохирох жолоодох эрхийн хүчин төгөлдөр үнэмлэх. Тухайн ангиллын тээврийн хэрэгслийг 3-аас дээш жил тасралтгүй жолоодсон байх. / хуулбараар/
- 4.Аюултай ачаа ачих болон тухайн ангилалд тохирох мэргэшсэн жолоочийн хүчин төгөлдөр үнэмлэх. / хуулбараар/
- 5.Тэсрэх материалтай харьцаж ажиллах эрхийн үнэмлэх. /нотломж хуулбараар/
- 6.Эрүүл мэндийн үзлэгийн хуудас./эх хувиар/
- 7.Тээврийн хэрэгслийн гэрчилгээ. Тухайн аж ахуйн нэгжийн бүртгэлтэй. / хуулбараар/
- 8.Тээврийн хэрэгслийг стандартын дагуу тусгайлан тоноглогсон тухай аж ахуйн нэгжийн тодорхойлолт, уг тээврийн хэрэгслийг 4 талаас нь авсан фото зураг. / Албан бичиг ирүүлсэн үед авсан зураг байх/
- 9.Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, оношилгоонд орж тэнцсэн дүгнэлт. /Тухайн жилдээ 2-оос доошгүй удаа техникийн үзлэгт хамрагдсан байх/
- 10.Автотээврийн хяналтын улсын байцаагчийн аюултай ачаа ачих стандарт шаардлага хангасан тухай дүгнэлт. /эх хувиар/
- 11.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэлтэй харьцах талаар аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгсөн талаар нотломж.
- 12.Автотээврийн хэрэгслийн албан татвар төлсөн тухай нотломж. /нотломж хуулбараар/
- 13.Жолоочийн хариуцлагын даатгал, авто тээврийн хэрэгслийн даатгалд хамрагдсан нотломж. / хуулбараар/
- 14.Энэ журмын 4.1, 4.2-т заасан тээврийн хэрэгсэлд тавих шаардлага, тээврийн хэрэгслийн иж бүрдлийг шалгасан тухай нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын тодорхойлолт. /эх хувиар/
- 15.Хуулийн этгээдийн болзошгүй ослын үед ажиллах төлөвлөгөө. /нотломж хуулбараар/
- 16.Хуулийн этгээд энэ журмын 4.3, 4.4, 4.5, 6.6 дахь нөхцөл шаардлагыг хангасан талаар нотломж, баримт бичиг. / хуулбараар/

Зөвшөөрлийн загвар: “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн аюулгүй ажиллагааны журам”-ын 10 дугаар зүйл 10.2-т заасан Маягт №1 загвар.

Зөвшөөрлийн хуулийн 5.3 дугаар зүйлийн 5.3.3 дахь хэсэгт “Хуульд өөрөөр заагаагүй бол эрх бүхий байгууллагын шийдвэр, эсхүл зөвшөөрөлд дараах мэдээллийг тусгана. Үүнд:

- 1.эрх бүхий этгээдийн нэр;
- 2.эрх бүхий этгээдийн шийдвэрийн нэр, он, сар, өдөр;
- 3.зөвшөөрөл эзэмшигчийн нэр,
- 4.зөвшөөрлийн ангилал, эрхлэх үйл ажиллагааны нэр;
- 5.зөвшөөрлийн хугацаа;
- 6.зөвшөөрлийн дугаар, олгосон он, сар, өдөр;
- 7.эрх бүхий этгээдийн гарын үсэг, тамга /тэмдэг/.

САНАМЖ Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн үед дараах зүйлийг хориглоно. Үүнд: 1.Тэсэрч дэлбэрэх бодисыг тэсэлгээний хэрэгслийн хамт тээвэрлэх; 2.Тээврийн хэрэгсэлд өөр төрлийн ачаа ачих, уг ачаатай хамааралгүй хүн авч явах; 3.Мэдээллийг бусдад дамжуулах. ШААРДЛАГАТАЙ УТАСНЫ ЖАГСААЛТ: Онцгой байдал - 101 Цагдаа - 102 Түргэн тусламж - 103 Аврах бүлэг - 105 ЦЕГ-ын шуурхай удирдлагын штаб - 70191010 Бүртгэл хяналтын төв - 70191515 Дотоодын царгийн 805 анги - 70191480	МОНГОЛ УЛС ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР NATIONAL POLICE AGENCY ЗӨВШӨӨРЛИЙН ҮНЭМЛЭХ License of permission	Хуулийн этгээдийн нэр Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль. 14 дүгээр зүйлТэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтэд тавих шаардлага 14.1 Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг зөвшөөрсгөөсөн чиглэлийн дагуу тээврийн болон аюултай ачааны стандартыг баримтлан тусгай тооцогдон тээврийн зориулалт аюулгүй байдлыг хангах, хариу хариуаагатай тээвэрлэх бөгөөд тээврийн хэрэгслийн зөвшөөрөл, тээвэрлэлтийн мэдээллийг цагдаагийн байгууллага олгох, хариу хариуаагатай дотоодын царгийн удирдлагын аюулгүй байдлыг хяналт тавина. 14.2 Тэсэрч дэлбэрэх бодисыг тэсэлгээний хэрэгслийн хамт тээвэрлэлийг хориглоно. 14.3 Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн ачаадагч болохыг зогсох, түнхээ урьчилсан сорилтоор захиарчигчтай тээврийн хэрэгслийг холбож болон агагдсан яваар хүн бүрт танилцуулж, аюулгүй байдлыг хангасан байна. 14.4 Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тоо, тоогон, бусад суурин газар тээвэрлэхдээ аюултай ачаа тээвэрлэх үеийн аюулгүй ажиллагааны төсвийн шаардлагыг хангасан байна. 14.5 Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг аюулгүй ажиллагааны шаардлага хангасан зориулалтын талбайд ачих, буулгана. 14.6 Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг төмөр замаар тээвэрлэхдээ төмөр замын тээврийн аюулалт эргэлсэн төрийн захиргааны төс байгууллага, тэнгүрлийн төс байгууллагын хамтран баталсан Төмөр замаар аюултай ачаа тээвэрлэх, ачих, буулгах, хадгалж, хуримт баримтлана. 14.7 Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн аюулгүй ажиллагааны журмыг цагдаагийн төс байгууллага, төсөлч, уул уурхайн аюулалт эргэлсэн төрийн захиргааны төс байгууллагатай хамтран батална. 14.8 Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн, тоо хэмжээг тооцогдон тээвэрлэх зориулалт тээврийн хэрэгслийн аюулгүй ажиллагааны болон байдал, даацыг харгалзан хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх буюу байгууллага олгоно. 14.9 Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн үеийн хариу хариуаагатай зэрэгдэл тухайн хуулийн этгээд хариуна. ЗӨВШӨӨРӨЛ № 20.../1..... Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Авто тээврийн тухай хууль, Авто замын тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Тэсэлгээний ачлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм, Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм, Авто тээврийн хэрэгсэлээр ачаа тээвэрлэх дүрэм, Авто тээврийн хэрэгсэлээр хүний амьс, эрүүл мэнд, хирээлэн буй орчид аюул, хохирол учруулж болохгүй ачаа тээвэрлэх журам болон холбогдох стандарт, тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн акт, Уул уурхайн хөдөлгөөний ачааны сайд, Цагдаагийн ерөнхий газрын даргын хамтран баталсан "Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн аюулгүй ажиллагааны журам"-д заасны дагуу: хуулийн этгээдийн өмчлөлийн.....оноосон нэршилтэй дугаартай.....улын дугаартай.....марк, загвартай.....зориулалттай тээврийн хэрэгсэлд "ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЭЛ" тээвэрлэх зөвшөөрөл олгог. Эхлэх хугацаа 20...оны...-р сарын...өдөр. Дуусах хугацаа 20...оны...-р сарын...өдөр. ДАРГА,
---	--	---

Төлбөр: Үгүй

Хураамж: Үгүй

Зөвшөөрөл олгох, сунгах үндэслэл журам: Зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйл. Зөвшөөрөл олгох, сунгах журам

Түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам: Зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар бүлэг. Зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох

Сэргээсэн, хүчингүй болгосон зөвшөөрлийн талаарх мэдээлэл: Зөвшөөрлийн тухай хуулийн 6.1, 6.2, 6.3, 6.4 дүгээр заалтуудыг үндэслэн

Хүчингүй болгосон зөвшөөрлийн талаарх мэдээлэл: Өнөөдрийн байдлаар хүчингүй болгосон энгийн зөвшөөрөл байхгүй.

Байгууллагын нэр: Цагдаагийн ерөнхий газрын Зөвшөөрөл, үйлчилгээний төв.

Байгууллагын хаяг, утасны дугаар: Баянгол дүүргийн 1 дүгээр хороо, Замчдын гудамж Премиум апартаментийн байр. Утас: 70191515

Хариуцсан албан тушаалтны нэр, утасны дугаар: Ахлах мэргэжилтэн, цагдаагийн дэд хурандаа Х.Отгонбаатар 94930008

ХУВИЙН ХАМГААЛАЛТ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ. /ААНБ/ /ИРГЭН/

Үйлчилгээний төрөл: Хувийн хамгаалалт эрхлэх тусгай зөвшөөрөл. /ААНБ/ /Иргэн/

Шийдвэрлэх журам: Хуулийн этгээд нь Монгол Улсын Хууль зүй, Дотоод хэргийн сайд, Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайдын хамтарсан 2018 оын А/119, А/377 дугаар тушаалаар баталсан “Хувийн хамгаалалтын сургалт явуулах зөвшөөрөл олгох, үйл ажиллагаанд нь хяналт тавих журам” Зөвшөөрлийн тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 8.1 дүгээр зүйлийн 11.11 дэх хэсэг, Хувийн хамгаалалтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 заалт, 5 дугаар зүйл, 6 дугаар зүйл, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалт.

Иргэн нь Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын хамтарсан 2018 оны А/119, А/377 дугаар тушаал “Хувийн хамгаалалтын сургалт явуулах, зөвшөөрөл олгох, үйл ажиллагаанд нь хяналт тавих журам”-ын шаардлага хангаж байх тул “Зөвшөөрлийн тухай” хуулийн 2.2 дугаар зүйлийн 1, 8.1 дүгээр зүйлийн 11.11, “Хувийн хамгаалалтын тухай” хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2, 5 дугаар зүйлийн 5.1, 5.2, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалт.

Хугацаа: Ажлын 10 хоног.

Бүрдүүлэх баримт бичиг: Хувийн хамгаалалт эрхлэх тусгай зөвшөөрөл авахыг хүссэн “**ХУУЛИЙН ЭТГЭЭД**” цагдаагийн байгууллагад дараах баримт бичгийг бүрдүүлж өгнө.

1. Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл.
2. Улсын бүртгэлийн гэрчилгээ.
3. Бие хамгаалагч тус бүрийн Иргэний үнэмлэхний лавлагаа, оршин суугаа газрын тодорхойлолт, эрүүл мэндийн тодорхойлолт, сургалтад хамрагдсан болохыг нотолсон баримт бичиг.
4. Хувийн хамгаалалт эрхлэх хуулийн этгээд нь үйл ажиллагаагаа явуулах бүтэц, зохион байгуулалт, боловсон хүчин, техник хэрэгсэл болон өөрийгөө санхүүжүүлэх чадвартайг нотолсон баримт бичиг. /Хувийн хамгаалалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дэх заалт /

Хувийн хамгаалалт эрхлэх тусгай зөвшөөрөл. / **ИРГЭН** /

1. Тусгай зөвшөөрөл олгохыг хүссэн өргөдөл.
2. Иргэний үнэмлэх /Лавлагаа/.
3. Оршин суугаа газрын тодорхойлолт /Лавлагаа/
4. Эрүүл мэндийн байгууллагын тодорхойлолт.
5. Хувийн хамгаалалтыг биечлэн гүйцэтгэх боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, мэргэжлийг нь дээшлүүлэх сургалтад хамрагдсан болохыг нотолсон баримт бичиг. /Хувийн хамгаалалтын тухай хуулийн 10 дугаар зүйл/

Хугацаа: Ажлын 10 хоног.

Гэрчилгээний загвар:

Хуулийн этгээд



Иргэн



Хураамж: Хувийн хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход хуулийн этгээд улсын тэмдэгтийн хураамж 2,500,000 төгрөг, иргэн 250,000 төгрөг.

Хураамж төлөх данс: Төрийн сан 100900000701.

Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ: Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн дагуу.

Төлбөр төлөх дансны мэдээлэл: Бүрдүүлэх материалын жагсаалтад үйлчилгээ үзүүлэх төлбөрийн данс байршуулсан.

Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа: 5 жил.

Тусгай зөвшөөрлийг Түдгэлзүүлэх, Сэргээх, Хүчингүй болгох: Зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйл.

Хүчингүй болгосон зөвшөөрлийн талаарх мэдээлэл: Өнөөдрийн байдлаар хүчингүй болгосон тусгай зөвшөөрөл байхгүй.

Байгууллагын нэр: Цагдаагийн ерөнхий газрын Зөвшөөрөл, үйлчилгээний төв.

Байгууллагын хаяг, утасны дугаар: Баянгол дүүргийн 1 дүгээр хороо, Замчдын гудамж Премиум апартаментийн байр. Утас: 70191515

Хариуцсан албан тушаалтны нэр, утасны дугаар: Ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахмад Н.Төрмөнх 95111062

МОНГОЛ УЛСЫН ЖОЛООДОХ ЭРХ АВАХ

Үйлчилгээний төрөл: Монгол улсын жолоодох эрх авах

Шийдвэрлэх журам: Тээврийн хэрэгсэл жолоодох эрх авах, ангилал нэмэх үйл ажиллагаа нь Монгол Улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 239 дүгээр тогтоолоор баталсан “Замын хөдөлгөөний дүрэм”, Хөдөлмөрийн сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2015 оны А/171, А/496 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх журам”, Хөдөлмөрийн сайд, боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2015 оны А/185, А/405 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх сургалтын хөтөлбөр”, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны А/46, А/09 дүгээр хамтарсан тушаалаар баталсан “Тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн шалгалт авах журам”, Хууль зүйн сайдын 2015 оны А/189 дүгээр тушаалаар баталсан “Жолоодох эрхийн үнэмлэх олгох журам”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны А/316 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах” /код-608/-аар зохицуулагдана.

Хугацаа: Тээврийн хэрэгсэл жолооч бэлтгэх сургалтын байгууллага /авто сургууль, курс/-д бүртгүүлэн тодорхой хөтөлбөрийн дагуу сургалтад хамрагдаж, цагдаагийн байгууллагын мэдээллийн санд бүртгүүлснээс хойш 14 хоногийн дараа шалгалтанд орох эрх үүснэ.

Нөхцөл шаардлага: 1. Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн 2 дахь хэсэгт зааснаар механикжсан тээврийн хэрэгслийг дор дурдсанаар ангилна:

- А-мотоцикл;
- В-жолоочоос гадна наймаас илүүгүй хүний суудалтай, бүх жин нь 3500 кг-аас хэтрэхгүй автомашин (бүх жин нь 750 кг-аас ихгүй чиргүүлтэй);
- С-“D” ангилалд хамаарагдахаас бусад бүх жин нь 3500 кг-аас их автомашин (бүх жин нь 750 кг-аас ихгүй чиргүүлтэй)
- D-жолоочоос гадна наймаас илүү хүний суудалтай, хүн тээвэрлэхэд зориулсан автомашин (бүх жин нь 750 кг-аас ихгүй чиргүүлтэй);
- BE-бүх жин нь 750 кг-аас илүү чиргүүлтэй “B” ангиллын автомашин;
- CE-бүх жин нь 750 кг-аас илүү чиргүүлтэй “C” ангиллын автомашин;
- DE-бүх жин нь 750 кг-аас илүү чиргүүлтэй “D” ангиллын автомашин болон угсраа автобус, угсраа троллейбус;
- M-трактор, өөрөө явдаг машин механизм, тэдгээрийн чиргүүл буюу ажлын тоног төхөөрөмжтэй бүрэлдэхүүн.
- “C”, “D”, “CE”, “DE” ангиллын тээврийн хэрэгслийг:
- C1-бүх жин нь 7500 кг-аас илүүгүй “C” ангиллын автомашин (бүх жин нь 750 кг-аас ихгүй чиргүүлтэй);
- D1-жолоочоос гадна арван зургаагаас илүүгүй хүний суудалтай “D” ангиллын автомашин (бүх жин нь 750 кг-аас ихгүй чиргүүлтэй);
- C1E-бүх жин нь 750 кг-аас илүү чиргүүлтэй “C1” дэд ангиллын автомашин;
- D1E-бүх жин нь 750 кг-аас илүү чиргүүлтэй “D1” дэд ангиллын автомашин гэж ангилна.
- “A”, “B”, “C”, “M” ангилал болон “C1” дэд ангиллын тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг арван найм, “D” ангилал болон “D1” дэд ангиллын тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хорин нэгээс дээш насны хүнд олгоно.
- “BE”, “CE”, “DE” ангиллын тээврийн хэрэгслийн бүрэлдэхүүн жолоодох эрхийг тухайн харгалзах “B”, “C”, “D” ангиллын тээврийн хэрэгсэл жолоодох эрх бүхий хүнд, түүнчлэн “C1E”, “D1E” дэд ангиллын тээврийн хэрэгслийн бүрэлдэхүүн жолоодох эрхийг тухайн харгалзах “C”, “D” ангилал буюу “C1”, “D1” дэд ангиллын тээврийн хэрэгсэл жолоодох эрх бүхий хүнд олгоно.
- “C”, “D” ангиллын тээврийн хэрэгсэл жолоодох эрх бүхий хүн нь тухайн харгалзах “C1”, “D1” дэд ангиллын тээврийн хэрэгслийг, мөн “CE”, “DE” ангиллын тээврийн хэрэгслийн бүрэлдэхүүн жолоодох эрх бүхий хүн нь тухайн харгалзах “C1E”, “D1E” дэд ангиллын тээврийн хэрэгслийн бүрэлдэхүүнийг жолоодох эрхтэй.

2.Тээврийн хэрэгсэл жолооч бэлтгэх сургалтын байгууллага /авто сургууль, курс/-д хамрагдсан иргэн дараах нөхцөлийг хангасан бол шалгалтад хамрагдаж, тэнцсэн тохиолдолд тухайн ангиллын тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэх авна:

- Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэмд заасан тухайн ангиллын тээврийн хэрэгслийг жолоодох эрх бүхий насанд хүрсэн;
- Эрүүл мэндийн байгууллагаас гаргасан тээврийн хэрэгсэл жолоодоход “тэнцэнэ” гэсэн эрүүл мэндийн үзлэгийн дүгнэлт авсан;
- Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх журмын дагуу жолоодох эрхийн шалгалтад орох үнэлгээний хуудсыг тус тус авсан байна.

Жолоодох эрхийн сургалт нь үндсэн болон ангилал нэмэх гэсэн 2 төрөлтэй бөгөөд аль нэг ангиллын тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэхгүй хүн үндсэн ангиллын сургалтад, үнэмлэхтэй хүн ангилал нэмэх сургалтад хамрагдаж болно. Үндсэн “А”, “В”, “М” ангиллын сургалт нь онолын 76, дадлагын сургалт нь “В” ангилалд 32, “А” болон “М” ангилалд тус тус 10 цагийн хугацаагаар, ганцаарчилсан хэлбэрээр, жолоодлогын дадлагын тусгай талбай /дром/, замын хөдөлгөөний бодит нөхцөл /хот/-д явагдана. Ангилал нэмэх “С” болон “D” ангиллын сургалт нь онолын 16, дадлагын 16, “BE”, “CE”, “DE” болон “А”, “М” ангиллын сургалт нь тус тус дадлагын 16 цагийн хичээлийн багтаамжтай байна.

Жич: “С” ангиллын сургалтад хамрагдах тохиолдолд “В” ангиллын тээврийн хэрэгслийг 3 сараас доошгүй, “D” ангиллын сургалтад хамрагдах тохиолдолд 21 нас хүрсэн, “В” ангиллын тээврийн хэрэгслийг 6 сараас доошгүй, “Е” ангиллын сургалтад хамрагдах тохиолдолд тухайн үндсэн ангиллын тээврийн хэрэгслийг 6 сараас доошгүй хугацаанд тус тус жолоодож дадлагажсан байх шаардлагатай. Үндсэн “А”, “В”, “М” ангиллын онолын шалгалтыг ерөнхий мэдлэгийн 20, ангилал нэмэх “С” болон “D” ангиллын онолын шалгалтыг нэмэлт мэдлэгийн 10 асуулт бүхий тестээр, үндсэн “В” ангиллын дадлагын шалгалтыг замын хөдөлгөөний бодит нөхцөл /хот/-д, бусад ангиллын шалгалтыг жолоодлогын талбай /дром/-д авна.

Бүрдүүлэх материал: 1. Тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн шалгалт авах журамд заагдсан үнэлгээний хуудас /Авто сургалтын байгууллагын сургалтад хамрагдаж хөтөлбөр хангасан суралцагчид олгоно/

2. Иргэний үнэмлэх, эсвэл жолоодох эрхийн үнэмлэх эх хувиар байхгүй бол цахимаас иргэний болон жолоочийн цаасан лавлагаа, гадаадын иргэн бол гадаад паспорт, МУ-д түр оршин суух үнэмлэх,

3. Цээж зураг 2% /4х6см/

4. Эрүүл мэндийн тодорхойлолт /Харьяалагдах дүүргийн Эрүүл мэндийн төвд эрүүл мэндийн үзлэгт орж “Эрүүл мэндийн үзлэгийн хуудас ЭММ-34 Б” маягтыг бөглүүлнэ/

5. Жолооны үнэмлэхийн үнэ 12.500 төгрөг тушаасан баримт.

Зөвшөөрлийн загвар: Монгол Улсын нэгдэн орсон Замын хөдөлгөөний тухай 1968 оны Венын конвенцын дагуу дараах дугаарлалтаар мэдээллийг тусгана. Үүнд:

Нүүрэн тал:

- 1.Эцэг (эх)-ийн нэр;
- 2.Өөрийн нэр;
- 3.Төрсөн огноо;
- 4.(a) Үнэмлэх олгосон огноо;
- 4.(b) Үнэмлэхийн хүчинтэй байх огноо;
- 4.(c) Үнэмлэх олгосон байгууллагын нэр, Олон улсын QR код ашиглан цахим хэлбэрээр шалгах хаяг;
- 5.Үнэмлэхийн дугаар;
- 6.Эзэмшигчийн зураг;
- 7.Эзэмшигчийн гарын үсэг;
- 9.Тээврийн хэрэгслийн ангилал (дэд ангилал)-ын хураангуй тэмдэглэл зэргийг Монгол, Англи хэлээр хэвлэнэ.

Ар тал:

- 1.Тээврийн хэрэгслийн ангилал (дэд ангилал)-ын томъёолол;
- 2.Тээврийн хэрэгслийн ангилал (дэд ангилал) тус бүрийн эрх олгосон огноо;
- 3.Тээврийн хэрэгслийн ангилал (дэд ангилал) тус бүрийн хүчинтэй байх огноо;
- 4.Тээврийн хэрэгслийн ангилал (дэд ангилал) бүрд хамаарах нэмэлт мэдээлэл болон хязгаарлалт зэрэг мэдээллийг хэвлэнэ.



Төлбөр: 12.500 төгрөг

Төлбөр төлөх дансны мэдээлэл: /Дансны дугаар: 100900012520, Хүлээн авагч банк - Төрийн сан банк, Хүлээн авагч байгууллага - ЦЕГ-ын жолооны үнэмлэх орлого, Гүйлгээний утга - овог, нэр, регистрийн дугаар/

Зөвшөөрөл олгох, сунгах үндэслэл журам: Зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар бүлэг. Зөвшөөрөл олгох, сунгах журам

Түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл журам: Зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар бүлэг. Зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх хүчингүй болгох.

Олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон зөвшөөрлийн талаарх мэдээлэл: Зөвшөөрлийн цахим сан (<https://license.mn>)-д байршуулсан.

Зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар төлөөлөгчийн газар: Зөвшөөрлийн цахим сан (<https://license.mn>)-д байршуулсан.

Зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа: 10 жил

Зөвшөөрөл олгосон байгууллагын нэр: Цагдаагийн ерөнхий газрын Зөвшөөрөл, үйлчилгээний төв.

Зөвшөөрөл олгосон байгууллагын хаяг, утасны дугаар: Баянгол дүүргийн 1 дүгээр хороо, Замчдын гудамж, Премиум апартамент. Утас: 70191515

Зөвшөөрөл хариуцсан албан тушаалтны нэр, утасны дугаар: Ахлах мэргэжилтэн, цагдаагийн дэд хурандаа В.Балжинням 80736363

ЖОЛООДОХ ЭРХИЙН ҮНЭМЛЭХ НӨХӨН АВАХ, СУНГАХ, СОЛИУЛАН АВАХ

Үйлчилгээний төрөл: Жолоодох эрхийн үнэмлэх нөхөн авах, сунгах, солиулан авах
Шийдвэрлэх журам: Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Хууль зүйн сайдын 2023 оны А/316 дугаар тушаалаар баталсан "Монгол Улсын жолоодох эрхийн үнэмлэхийн загвар", "Монгол Улсын Олон улсын жолоодох эрхийн үнэмлэхийн загвар", "Жолоодох эрхийн түр зөвшөөрлийн загвар", "Тээврийн хэрэгслийн ангилал (дэд ангилал) бүрд хамаарах нэмэлт мэдээлэл болон хязгаарлалт", Хууль зүйн сайдын 2015 оны А/189 дүгээр тушаалаар баталсан "Жолоодох эрхийн үнэмлэх олгох журам"-аар тус тус зохицуулагдсан.

Хугацаа: Ажлын 14 хоног.

Нөхцөл шаардлага, бүрдүүлэх материал:

1. Үндэсний жолоодох эрхийн үнэмлэх нөхөн авах, хугацаа сунгах, солиулан авах үйлчилгээг Монгол Улсын иргэд 3 хэлбэрээр авах боломжтой.

1.1. Портал буюу цахимаар захиалах иргэд өөрийн бүртгэлтэй email хаяг, гар утасны дугаартай байх шаардлагатай бөгөөд "E-Mongolia" аппликейшнийг татан авч, "Үйлчилгээнүүд" цэсний "Жолооны үнэмлэх солих, нөхөх" хэсгийг сонгон нэвтэрч, хүсэлтээ илгээнэ. Жолооны үнэмлэхийн төлбөр болон зөрчлийн торгуулийг smartcar.mn, Гэрэгэ систем, QPay, цахим банк зэрэг төлбөр тооцооны бүх хэлбэрийг ашиглан төлөх боломжтой бөгөөд бичиг баримт бүрдүүлэх шаардлагагүй.



1.2. Операторын буюу Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн 6 салбар /БЗД-ийн "Дүнжингарав" худалдааны төв, СХД-ийн "Драгон" төв, Баянхошуу Жанцаны буудал "Бизнес инкубатор" төв, ЧД-ийн Чингэлтэйн 1 дүгээр буудал "Сэлбэ" дэд төв, БГД-ийн III хорооллын эцэс "Соло молл" /И-март/ төв, ХУД-ийн "Мишээл экспо" төв/-т биеэр хандаж буй иргэд өөрийн нотлох бичиг баримтыг авч очих, эсвэл цахим лавлагаагаар жолоодох эрхийн үнэмлэхээ захиална.



1.3. Дүнжингарав худалдааны төв болон Драгон төв дээр 2 ширхэг жолоодох эрхийн үнэмлэхийг шууд хэвлэх автомат киоск байршуулсан. Автомат киоскоор үйлчлүүлэхдээ иргэний цахим үнэмлэх, И-Монголиа системд бүртгэлтэй утасны дугаар эсхүл цахим гарын үсгийн хамтаар очиж 2-3 минутын дотор жолоодох эрхийн хүчинтэй хугацаа сунгах, нөхөн авах боломжтой.



2. Монгол Улсын үндэсний жолоодох эрхийн үнэмлэх олгогдсон гадаад улсын иргэд жолоодох эрхийн үнэмлэх нөхөн авах, хүчинтэй хугацаа сунгах, хуучирч муудсаныг солиулахад доорх бичиг баримтыг бүрдүүлэн өөрийн биеэр тус төвийн үйлчилгээний танхимаар үйлчлүүлнэ:

1. Жолоочийн бүртгэлийн маягт бөглөх /Маягтыг үйлчилгээний танхимаас авна/

2. Гадаад паспорт, түүний хуулбар;
3. Жолооны үнэмлэхийн үнэ 12.500 төгрөг тушаасан баримт.

Анхаарах асуудал: Цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлах /ASAP/ санд зарлагдсан, бэлэн бус торгуулийн шийтгэлийг төлөөгүй, зам тээврийн осол хэрэг, зөрчлийн улмаас эрх нь хязгаарлагдсан шалтгаантай иргэд захиалга өгөх боломжгүй.

Зөвшөөрлийн загвар: Монгол Улсын нэгдэн орсон "Замын хөдөлгөөний тухай" 1968 оны Венийн конвенцийн дагуу дараах дугаарлалтаар мэдээллийг тусгана. Үүнд:

Нүүрэн тал:

- 1.Эцэг (эх)-ийн нэр;
- 2.Өөрийн нэр;
- 3.Төрсөн огноо;
- 4.(a) Үнэмлэх олгосон огноо;
- 4.(b) Үнэмлэхийн хүчинтэй байх огноо;
- 4.(c) Үнэмлэх олгосон байгууллагын нэр, Олон улсын QR код ашиглан цахим хэлбэрээр шалгах хаяг;
- 5.Үнэмлэхийн дугаар;
- 6.Эзэмшигчийн зураг;
- 7.Эзэмшигчийн гарын үсэг;
- 9.Тээврийн хэрэгслийн ангилал (дэд ангилал)-ын хураангуй тэмдэглэл зэргийг Монгол, Англи хэлээр хэвлэнэ.

Ар тал:

- 1.Тээврийн хэрэгслийн ангилал (дэд ангилал)-ын томьёолол;
- 2.Тээврийн хэрэгслийн ангилал (дэд ангилал) тус бүрийн эрх олгосон огноо;
- 3.Тээврийн хэрэгслийн ангилал (дэд ангилал) тус бүрийн хүчинтэй байх огноо;
- 4.Тээврийн хэрэгслийн ангилал (дэд ангилал) бүрд хамаарах нэмэлт мэдээлэл болон хязгаарлалт зэрэг мэдээллийг хэвлэнэ.



Төлбөр: 12.500 төгрөг

Төлбөр төлөх дансны мэдээлэл: /Дансны дугаар: 100900012520, Хүлээн авагч банк - Төрийн сан банк, Хүлээн авагч байгууллага - ЦЕГ-ын жолооны үнэмлэх орлого, Гүйлгээний утга - овог, нэр, регистрийн дугаар/

Зөвшөөрөл олгох, сунгах үндэслэл журам: Зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар бүлэг. Зөвшөөрөл олгох, сунгах журам

Түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл журам: Зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар бүлэг. Зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх хүчингүй болгох.

Олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон зөвшөөрлийн талаарх мэдээлэл: Зөвшөөрлийн цахим сан (<https://license.mn>)-д байршуулсан.

Зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар төлөөлөгчийн газар: Зөвшөөрлийн цахим сан (<https://license.mn>)-д байршуулсан.

Зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа: 10 жил

Зөвшөөрөл олгосон байгууллагын нэр: Цагдаагийн ерөнхий газрын Зөвшөөрөл, үйлчилгээний төв.

Зөвшөөрөл олгосон байгууллагын хаяг, утасны дугаар: Баянгол дүүргийн 1 дүгээр хороо, Замчдын гудамж, Премиум апартамент. Утас: 70191515

Зөвшөөрөл хариуцсан албан тушаалтны нэр, утасны дугаар: Ахлах мэргэжилтэн, цагдаагийн дэд хурандаа В.Балжинням 80736363

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ЖОЛООДОХ ЭРХИЙН ҮНЭМЛЭХ АВАХ

Үйлчилгээний төрөл: Монгол улсын олон улсын жолоодох эрхийн үнэмлэх авах
Шийдвэрлэх журам: “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль”-ын 16 дугаар зүйл 16.1, 16.2 дугаар заалт, Хууль зүйн сайдын 2015 оны А/189 дүгээр тушаалаар баталсан “Жолоодох эрхийн үнэмлэх олгох журам”-ын 4 дүгээр зүйл, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны А/316 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах” /код-608/

Хугацаа: Ажлын 7 хоног.

Нөхцөл, шаардлага:

1. Монгол Улсын олон улсын жолоодох эрхийн үнэмлэх шинээр болон нөхөн авах Монгол Улсын иргэд энэхүү үйлчилгээг 2 хэлбэрээр авах боломжтой.

1.1. Портал буюу цахимаар захиалах иргэд өөрийн бүртгэлтэй email хаяг, гар утасны дугаартай байх шаардлагатай бөгөөд “E-Mongolia” аппликейшныг татан авч, “Үйлчилгээнүүд” цэсний “Олон улсын жолооны үнэмлэх” хэсгээс хугацааны сонголтоор нэвтэрч, хүсэлтээ илгээнэ. Жолооны үнэмлэхийн төлбөр болон зөрчлийн торгуулийг smartcar.mn, Гэрэгэ систем, QPay, цахим банк зэрэг төлбөр тооцооны бүх хэлбэрийг ашиглан төлөх бөгөөд баримт бичиг бүрдүүлэх шаардлагагүй.



1.2. Операторын буюу Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн 6 салбар /БЗД-ийн “Дүнжингарав” худалдааны төв, СХД-ийн “Драгон” төв, Баянхошуу Жанцаны буудал “Бизнес инкубатор” төв, ЧД-ийн Чингэлтэйн 1 дүгээр буудал “Сэлбэ” дэд төв, БГД-ийн III хорооллын эцэс “Соло молл” /И-март/ төв, ХУД-ийн “Мишээл экспо” төв/-т биеэр хандаж буй иргэд өөрийн нотлох бичиг баримтыг авч очин олон улсын жолоодох эрхийн үнэмлэхээ захиалан авна.

2. Монгол Улсын олон улсын жолоодох эрхийн үнэмлэх олгогдсон гадаад улсын иргэд жолоодох эрхийн үнэмлэх нөхөн авах, хүчинтэй хугацаа сунгах, хуучирч муудсаныг солиулахад доорх бичиг баримтыг бүрдүүлэн өөрийн биеэр тус төвийн үйлчилгээний танхимаар үйлчлүүлнэ:

1. Жолоочийн бүртгэлийн маягт бөглөх /Маягтыг үйлчилгээний танхимаас авна/;
2. Гадаад паспорт, түүний хуулбар, Монгол Улсын үндэсний жолоодох эрхийн үнэмлэх, түүний хуулбар.

Анхаарах асуудал: Цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлах /ASAP/ санд зарлагдсан, бэлэн бус торгуулийн шийтгэлийг төлөөгүй, зам тээврийн осол хэрэг, зөрчлийн улмаас эрх нь хязгаарлагдсан шалтгаантай иргэд захиалга өгөх боломжгүй.

Зөвшөөрлийн загвар: Монгол Улсын Олон улсын жолоодох эрхийн үнэмлэх нь Замын хөдөлгөөний тухай 1968 оны Венын конвенцын дагуу А6 (148x105 мм) форматын хэмжээтэй цаасан дэвтэр байна. Мөн сайжруулсан цаасан хавтастай нүүрэн хэсэгт алтлаг клишетэй, товгор бичвэртэй, дотор хэсэгт шаргал өнгийн түмэн насан хээтэй 6 хуудас, 12 нүүртэй байна.

Үүнд:

1. Үнэмлэхийн эхний нүүрэнд Олон улсын жолоодох эрхийн үнэмлэхийн дугаар, хүчинтэй байх огноо, олгосон огноо, Монгол Улсын жолоодох эрхийн үнэмлэхийн дугаар зэргийг бичих ба олгосон байгууллагын мэдээллийг тусгаж, үнэмлэх олгосон албан тушаалтны гарын үсэг, байгууллагын тэмдгээр баталгаажуулна.
2. Хоёроос тав дахь нүүрэнд Монгол болон Англи хэлээр Венийн конвенцийн гишүүн орнуудын жагсаалт, хамаарал бүхий заалт;
3. Зургаагаас арав дахь нүүрэнд Англи, Франц, Орос, Герман, Испани хэл дээр эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, төрсөн огноо, газар, тээврийн хэрэгслийн ангилал (дэд ангилал)-ын тэмдэглэл, хүлээн зөвшөөрсөн улсаас тээврийн хэрэгсэл ашиглалттай холбоотой бусад хязгаарлалтын тэмдэглэл;
4. Арваннэгдүгээр нүүрэнд хүлээн зөвшөөрсөн улсад тээврийн хэрэгсэл жолоодох эрх хассан тэмдэглэл;
5. Арванхоёрдугаар нүүрэнд:
 - Эцэг (эх) ийн нэр;
 - Өөрийн нэр;

- Төрсөн огноо;
- Төрсөн улс;
- Төрсөн газар;
- Тээврийн хэрэгслийн ангилал (дэд ангилал)-ын тэмдэглэл;
- Эзэмшигчийн зураг болон цагдаагийн бэлгэдэл (галаграм);
- Эзэмшигчийн гарын үсэг;
- Эрх бүхий байгууллагаас жолоодох эрх хассан тэмдэглэл зэргийг Англи хэлээр бичнэ



Төлбөр: 1 жил 20.000 төгрөг, 2 жил 40.000 төгрөг, 3 жил 60.000 төгрөг

Төлбөр төлөх дансны мэдээлэл: Хүлээн авагч банк - Төрийн сан банк, дансны дугаар: 100900012520

Зөвшөөрөл олгох, сунгах үндэслэл журам: Зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар бүлэг. Зөвшөөрөл олгох, сунгах журам

Түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл журам: Зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар бүлэг. Зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх хүчингүй болгох.

Олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон зөвшөөрлийн талаарх мэдээлэл: Зөвшөөрлийн цахим сан (<https://license.mn>)-д байршуулсан.

Зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар төлөөлөгчийн газар: Зөвшөөрлийн цахим сан (<https://license.mn>)-д байршуулсан.

Зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа: 1 жил, 2 жил, 3 жил.

Зөвшөөрөл олгосон байгууллагын нэр: Цагдаагийн ерөнхий газрын Зөвшөөрөл, үйлчилгээний төв.

Зөвшөөрөл олгосон байгууллагын хаяг, утасны дугаар: Баянгол дүүргийн 1 дүгээр хороо, Замчдын гудамж, Премиум апартамент. Утас: 70191515

Зөвшөөрөл хариуцсан албан тушаалтны нэр, утасны дугаар: Ахлах мэргэжилтэн, цагдаагийн дэд хурандаа В.Балжинням 80736363

ГАДААД УЛСЫН ЖОЛООДОХ ЭРХИЙН ҮНЭМЛЭХИЙГ МОНГОЛ УЛСЫН ЖОЛООДОХ ЭРХИЙН ҮНЭМЛЭХЭЭР СОЛИУЛАХ

Үйлчилгээний төрөл: Гадаад улсын жолоодох эрхийн үнэмлэхийг монгол улсын жолоодох эрхийн үнэмлэхээр солиулах

Шийдвэрлэх журам: Монгол Улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Хууль зүйн сайдын 2015 оны А/189 дүгээр тушаалаар баталсан “Жолоодох эрхийн үнэмлэх олгох журам”-аар зохицуулагдсан.

Хугацаа: Ажлын 5 хоног.

Нөхцөл, шаардлага, бүрдүүлэх материал:

1. Венын конвенцын гишүүн орноос олгогдсон жолоодох эрхийн үнэмлэхийг Монгол Улсын үндэсний жолоодох эрхийн үнэмлэхээр солиулах

Замын хөдөлгөөний тухай Венын конвенцын гишүүн орноос олгосон, уг конвенцод нийцсэн хүчин төгөлдөр жолоодох эрхийн үнэмлэх бүхий Монгол Улсын болон гадаад улсын иргэн Замын хөдөлгөөний хууль дүрмийн шалгалтад хамрагдахгүйгээр Монгол Улсын үндэсний жолоодох эрхийн үнэмлэхийг авч болно.

1. Жолоочийн бүртгэлийн маягт бөглөх / Маягтыг өөрийн биеэр ирж үйлчилгээний танхимаас авна/

2. Иргэний үнэмлэх, эсхүл гадаад паспорт, түүний хуулбар, эсвэл иргэний үнэмлэхийн лавлагаа

3. Тухайн улсын үндэсний жолоодох эрхийн үнэмлэх эх хувиар, түүний хуулбар, баталгаат орчуулга

4. Цээж зураг 2% /4х6см/

5. Эрүүл мэндийн тодорхойлолт /Харьяалагдах дүүргийн Эрүүл мэндийн төвд эрүүл мэндийн үзлэгт орж “Эрүүл мэндийн үзлэгийн хуудас ЭММ-34 Б” маягтыг бөглүүлнэ/

6. Жолооны үнэмлэхийн үнэ 12.500 төгрөг тушаасан баримт.

Жич: Гадаад улсын иргэн уг конвенцод нийцсэн, хүчин төгөлдөр үнэмлэхээр Монгол Улсад нэвтэрснээс хойш 1 жилийн хугацаанд тээврийн хэрэгсэл жолоодож болно.

2. Венын конвенцын гишүүн бус орноос олгогдсон жолоодох эрхийн үнэмлэхийг Монгол Улсын үндэсний жолоодох эрхийн үнэмлэхээр солиулах

Замын хөдөлгөөний тухай Венын конвенцын гишүүн бус орноос олгосон жолоодох эрхийн үнэмлэх бүхий Монгол Улсын болон гадаад улсын иргэн Замын хөдөлгөөний хууль, дүрмийн 20 асуулт бүхий тестийн шалгалтад хамрагдаж, тэнцсэн тохиолдолд Монгол Улсын үндэсний жолоодох эрхийн үнэмлэхийг авна.

1. Жолоочийн бүртгэлийн маягт бөглөх / Маягтыг өөрийн биеэр ирж үйлчилгээний танхимаас авна/

2. Иргэний үнэмлэх, эсхүл гадаад паспорт, түүний хуулбар, эсвэл иргэний үнэмлэхийн лавлагаа

3. Тухайн улсын үндэсний жолоодох эрхийн үнэмлэх эх хувиар, түүний хуулбар, баталгаат орчуулга

4. Цээж зураг 2% /4х6см/

5. Эрүүл мэндийн тодорхойлолт /Харьяалагдах дүүргийн Эрүүл мэндийн төвд эрүүл мэндийн үзлэгт орж “Эрүүл мэндийн үзлэгийн хуудас ЭММ-34 Б” маягтыг бөглүүлнэ/

6. Жолооны үнэмлэхийн үнэ 12.500 төгрөг тушаасан баримт.

Тайлбар: Замын хөдөлгөөний хууль, дүрмийн шалгалтыг 6 сарын хугацаанд сард 1 удаа хамрагдах боломжтой.

3. Гадаад улсын иргэд Монгол Улсын үндэсний жолоодох эрхийн үнэмлэхийн хүчинтэй хугацааг сунгах, нөхөн авахад дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

1. Жолоочийн бүртгэлийн маягт бөглөх / Маягтыг өөрийн биеэр ирж үйлчилгээний танхимаас авна/

2. Гадаад паспорт, түүний хуулбар

3. Жолооны үнэмлэхийн үнэ 12.500 төгрөг тушаасан баримт.

Зөвшөөрлийн загвар: Монгол Улсын нэгдэн орсон Замын хөдөлгөөний тухай 1968 оны Венын конвенцын дагуу дараах дугаарлалтаар мэдээллийг тусгана. Үүнд:

Нүүрэн тал:

1.Эцэг (эх)-ийн нэр;

2.Өөрийн нэр;

3.Төрсөн огноо;

4.(а) Үнэмлэх олгосон огноо;

4.(b) Үнэмлэхийн хүчинтэй байх огноо;

4.(c) Үнэмлэх

олгосон

байгууллагын

нэр, олон улсын QR код ашиглан цахим хэлбэрээр шалгах хаяг;

5.Үнэмлэхийн дугаар;

6.Эзэмшигчийн зураг;

7.Эзэмшигчийн гарын үсэг;

8.Тээврийн хэрэгслийн ангилал (дэд ангилал)-ын хураангуй тэмдэглэл зэргийг Монгол, Англи хэлээр хэвлэнэ.

Ар тал:

1.Тээврийн хэрэгслийн ангилал (дэд ангилал)-ын томъёолол;

2.Тээврийн хэрэгслийн ангилал (дэд ангилал) тус бүрийн эрх олгосон огноо;

3.Тээврийн хэрэгслийн ангилал (дэд ангилал) тус бүрийн хүчинтэй байх огноо;

4.Тээврийн хэрэгслийн ангилал (дэд ангилал) бүрд хамаарах нэмэлт мэдээлэл болон хязгаарлалт зэрэг мэдээллийг хэвлэнэ.



Төлбөр: 12.500 төгрөг

Төлбөр төлөх дансны мэдээлэл: /Дансны дугаар: 100900012520, Хүлээн авагч банк -Төрийн сан банк, Хүлээн авагч байгууллага - ЦЕГ-ын жолооны үнэмлэх орлого, Гүйлгээний утга - овог, нэр, регистрийн дугаар/

Зөвшөөрөл олгох, сунгах үндэслэл журам: Зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар бүлэг. Зөвшөөрөл олгох, сунгах журам

Түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл журам: Зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар бүлэг. Зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх хүчингүй болгох.

Олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон зөвшөөрлийн талаарх мэдээлэл: Зөвшөөрлийн цахим сан (<https://license.mn>)-д байршуулсан.

Зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар төлөөлөгчийн газар: Зөвшөөрлийн цахим сан (<https://license.mn>)-д байршуулсан.

Зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа: 10 жил

Зөвшөөрөл олгосон байгууллагын нэр: Цагдаагийн ерөнхий газрын Зөвшөөрөл, үйлчилгээний төв.

Зөвшөөрөл олгосон байгууллагын хаяг, утасны дугаар: Баянгол дүүргийн 1 дүгээр хороо, Замчдын гудамж, Премиум апартмент. Утас: 70191515

Зөвшөөрөл хариуцсан албан тушаалтны нэр, утасны дугаар: Ахлах мэргэжилтэн, цагдаагийн дэд хурандаа В.Балжинням 80736363